



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 06 сарын 18 өдөр

Дугаар 4/105

Булган сум

“Булганы сэргэлт” хөтөлбөрийг сурталчлахад хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.2, 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.4 дэх заалт, Аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны “Булганы сэргэлт” хөтөлбөрийг батлах тухай Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны IV/25, Булган аймгийн 2025 оны төсөв батлах тухай Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны IV/26 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Булган аймгийн Засаг даргын “Булганы сэргэлт” хөтөлбөрийг иргэд олон нийтэд сурталчлах зардлыг хавсралтаар батлан гэрээ байгуулж, хамтран ажиллахыг Аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Д.Наранбаяр)-д даалгасугай.


2.Сурталчилгааны зардалд шаардагдах 19,025,000 (арван есөн сая хорин таван мянга) төгрөгийг Аймгийн Засаг даргын Тамгын газрын төсвөөс гаргахыг Аймгийн Засаг даргын Тамгын газрын Ахлах нягтлан бодогч (Д.Баясгалан)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА

Д.ПҮРЭВ-ОЧИР



Аймгийн Засаг даргын 2025 оны
... дугаар сарын ...-ны/ний өдрийн ... дүгээр
захирамжийн хавсралт



СУРТАЛЧИЛГААНЫ ЗАРДАЛ

д/д	Зардлын зориулалт	Тоо хэмжээ	Мөнгөн дүн
1	2	3	4
1	"Өдрийн сонин"	1	2,400,000
2	"Тунхаг бичиг" ХХК	1500	15,025,000
3	"Титэм дизайн" ХХК	50	1,600,000
	Нийт		19,025,000